



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/1495

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.5, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2012 оны А/299 дүгээр тушаалаар батлагдсан "Монгол Улсын нутаг дэвсгэр дээр идлэг шонхор амьдаар нь барих, тээвэрлэх, арчлах, экспортод гаргах үйл ажиллагаанд мөрдөх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт идлэг шонхор шувууг соёлын зориулалтаар амьдаар нь барих, арчлах, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Биологийн төрөл зүйл, хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Цагдаагийн газрын Эдийн засгийн ахлах мөрдөгч Тагнуулын хэлтсийн Инженер, ажилтан Гадаадын харьяатын газрын Хэнтий аймаг дахь мэргэжилтэн Тухайн сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч

2. Идлэг шонхор шувууг амьдаар барих, тээвэрлэх, арчлах үйл ажиллагаанд болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэл үр дүнгийн талаар танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ